

МОНГОЛБАНКНЫ ТЭРГҮҮН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ  
Б. ЖАВХЛАНГИЙН ХЭЛСЭН ҮГ

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгаж Монголбанкнаас зохион байгуулж байгаа Хэвлэлийн хуралд хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлье.

“Монголбанкны хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам” батлагдсаны дараахан болж байгаагаараа энэ удаагийн Хэвлэлийн хурал ихээхэн онцлог юм. Үүнээс хойш та бид сар болгон уулзаж Монгол улсын макро эдийн засаг, мөнгө ханшийн бодлого, банк санхүүгийн салбарын төлөв байдлын талаар санал бодлоо солилцож байх болно.

Хэвлэлийн хурлыг тогтмол зохион байгуулснаар Монголбанк бодлогын шийдвэрүүдээ олон нийтэд хүргэх, таниулах, сурталчлах өргөн боломж нээгдэх юм. Монголбанкны бодлогын хэрэгсэлд өөрчлөлт орохооргүй байсан ч яагаад гэдгээ бид тайлбарлаж байх болно.

Бодлогод өөрчлөлт оруулах эсэхийг олон нийтэд ил тод, нээлттэй, тогтмол давтамжтайгаар хүргэж, тайлбарладаг болох нь санхүүгийн захын тодорхойгүй байдлыг арилгах, улмаар эрсдлийг бууруулах, инфляцийн хүлээлтэд нөлөөлөхөд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.

Монголбанк үйл ажиллагаагаа улам нээлттэй, ил тод байлгахын төлөө ажиллах болно. Нээлттэй, ил тод байна гэдэг нь тухайн бодлогын шийдвэрийг яагаад гаргасныг, ингэснээр ямар үр дүн хүлээгдэж байгааг тайлбарлаж, олон нийтийн эргэлзээ, тодорхой бус байдлыг арилгахын нэр юм.

Нээлттэй, ил тод байна гэдэг нь авч буй арга хэмжээний эерэг талыг төдийгүй, богино хугацаанд үүсч болох сөрөг нөлөөг ч үнэлэхийн нэр юм. Нээлттэй, ил тод байж гэмээнэ олон нийтийн зүгээс Төв банкинд итгэх итгэл сэргэж мөнгөний бодлого жинхэнэ утгаараа үр өгөөжтэй хэрэгжих үндэс бүрдэнэ.

Харамсалтай нь Монголбанкны үйл ажиллагааг буруу зөрүү тайлбарлах, мушгин гуйвуулах явдал тасрахгүй байна. Зарим тохиолдолд зохион байгуулалттай гүтгэж байгаа нь ч нууц биш. Санаатай санаагүй буруу ташаа мэдээлэл тараах нь эргээд санхүүгийн захын хөгжлийг чөдөрлөж, эцсийн дүндээ монголчууд та бидний хөгжилд л сөргөөр нөлөөлөх болно. Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд сэтгүүлчид та бүхний үүрэг асар их гэдгийг би энд зориуд онцлон хэлэхийг хүсч байна. Монголбанк та бүхний ур чадвар, ёс зүйд итгэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.